# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 6 сарын 09 өдөр Дугаар А/133 Улаанбаатар хот

Маягт, заавар батлах тухай

Гаалийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлж хөнгөн шуурхай болгох зорилгоор Гаалийн тухай хуулийн 271.1.1 дэх заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1.“Гаалийн бүрдүүлэлтийн хуудас” Маягт№2-ын загварыг 1 дүгээр, түүнийг цахим хэлбэрээр бүрдүүлэх зааврыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажилахыг Гаалийн газар, хороодын дарга нарт даалгасугай

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн ерөнхий газрын дэд дарга Н.Энхцогтод үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2015 оны А/79 тоот тушаал, 2011 оны 679 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Гаалийн бүрдүүлэлтийн хуудас” Маягт№2-ын загвар, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Гаалийн бүрдүүлэлт, санхүүгийн үйл ажиллагаанд хөтлөгдөх маягт, түүнийг бүрдүүлэх заавар”-ын “Маягт нөхөн бичих” хэсгийн “Гаалийн бүрдүүлэлтийн хуудас, Маягт№2”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Б.ЦЭНГЭЛ

0000562

МАЯГТ №2

Гаалийн Ерөнхий газрын даргын
2015 оны 133 дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

# ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ХУУДАС №

ОН САР ӨДӨР

.......................................................

...............................................................................................................................

Манифест дугаар: Тээврийн хэрэгсэл дугаар

| Д/Д | Илгээгч улсын код, нэр | Барааны | | Хэмжих нэгж | Тоо | Үнийн дүн | Ноогдуулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нэр | Код | | | | Татвар | Хураамж |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Бүгд | | | | | | | | |
| | | | | | | | | |

Валютын төрөл ______ ханш __________ Төлбөрийн баримтын № ______________

Татвар хураамжийн дүн үсгээр/ ______________________________________ /

Гаалийн Улсын байцаагч _____/___/________ Мэдүүлэгч ________ ________
/Гарын үсэг, тэмдэг/

---

МАЯГТ №2

Гаалийн Ерөнхий газрын даргын
оны дугаар тушаалын
1 дүгээр хавсралт

# ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТИЙН ХУУДАС №

ОН САР ӨДӨР

.......................................................

...............................................................................................................................

Манифест дугаар: Тээврийн хэрэгсэл дугаар

| Д/Д | Илгээгч улсын код, нэр | Барааны | | Хэмжих нэгж | Тоо | Үнийн дүн | Ноогдуулсан | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Нэр | Код | | | | Татвар | Хураамж |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Бүгд | | | | | | | | |
| | | | | | | | | |

Валютын төрөл ______ ханш __________ Төлбөрийн баримтын № ______________

Татвар хураамжийн дүн үсгээр/ ______________________________________ /

Гаалийн Улсын байцаагч _____/___/________ Мэдүүлэгч ________ ________
/Гарын үсэг, тэмдэг/

252

Гаалийн ерөнхий газрын даргын 2015 оны

133 тоот тушаалын 2 дугаар хавсралт

УХГ0035

**Гаалийн бүрдүүлэлтийн хуудас, Маягт№2-ыг цахим хэлбэрээр бүрдүүлэх заавар**

1. CAIS програмын “**Гаалийн бүрдүүлэлт**” цэсний “**Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас**” хэсгийн “**Дэлгэрэнгүй**” гэсэн хэсэг рүү орж “Нэмэх” товчийг дарна.




1.1. Ачааны манифест болон гадаад худалдаа эрхлэгчийн мэдээлэл оруулах.

| № | Хүснэгтийн нэр | Тайлбар /гүйцэтгэх үүрэг/ |
|---|---|---|
| 1. | Гормын код | Гаалийн бүрдүүлэлтийн гормыг сонгох. |
| 2.Ачааны манифест | Манифестийн№ | Манифестээр гаалийн хяналтанд авагдсан бараа байх тохиолдолд энэ хүснэгт ашиглах./Төмөр зам, Агаарын зам, Гүний гаальд авто замын манифестэй хяналтанд ирсэн бараа/ |
| | Тээврийн хэрэгслийн дугаар | Хилийн гаальд бүрдүүлэлт хийгдэж буй бараа авто замаар тээвэрлэгдэж хилээр орж нэвтэрсэн тохиолдолд тээврийн хэрэгслийн дугаарыг сонгох. |
| | Татвартай эсэх | Маягт№2 гэсэн хэсгийг сонгох |
| | Нийт баглаа боодол | Баглаа боодлын тоо ширхэг, кодыг сонгох. |
| | Хураамж | Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хураамжийн дүн “1200” төгрөгийг бичих. |
| | Бохир жин | Тухайн барааны бохир жинг бичих. |
| | Хатуу дугаар | “Маягт№2-ын хатуу дугаарыг бичих./5484354 гэх мэт/ |
| | Экспорт/Импорт улс | Бараа илгээгч/хүлээн авагч улсын кодыг сонгох. |
| 3.Гадаад худалдаа эрхлэгч | Нэр | “Поп-ап” товчийг ашиглан CAIS системийн “Гадаад худалдаа эрхлэгчийн сан”-гаас бүрдүүлэлт хийлгэж буй иргэний бүртгэлийн мэдээллийг регистрийн дугаараар хайлт хийхэд |

1.2. **"**Бараанууд" гэсэн хэсгийн "Нэмэх" товчийг ашиглан




| № | Хүснэгтийн нэр | Тайлбар /гүйцэтгэх үүрэг/ |
|---|---|---|
| 1 | Барааны нэр | Гаалийн бүрдүүлэлт хийж буй барааны нэрийг унификацын дагуу бичих. |
| 2 | Барааны код | Барааны БТКУС кодыг 4 орны түвшинд бичих. Жич:www.customs.gov.mn сайтын "Гадаад худалдааны барааны ангилалын жагсаалт" цэсийг ашиглана уу. |
| 3 | Гарал үүслийн улс | Гаалийн бүрдүүлэлт хийж буй барааны гарал үүслийн улсыг сонгох. |
| 4 | Хэлцлийн тоо хэмжээ | Барааны тоо ширхэгийг бичиж, хэмжих нэгжийн кодыг сонгох. |
| 5 | Нийт жин | Тухайн барааны нийт жинг бичих. |
| 6 | Гаалийн нэгж үнэ | Барааны нэгж үнийг бичээд тухайн валютын кодыг сонгох. |
| 7 | Гаалийн нэгж үнэ /USD/ | Автоматаар хөрвөж орно. |
| 8 | "Хадгалах" товч | Мэдээллийг бүрэн гүйцэд оруулж дуусаад "Хадгалах" товчийг дарна. |

1.3. Мэдээллийг оруулж дуусаад "Баталгаажуулах" товчийг дарна.

**2**. Хадгалах товчийг дарснаар гаалийн болон бусад татварыг ногдуулж "төлбөрийн нэхэмжлэх" програмд автоматаар үүснэ. Гадаад худалдаа эрхлэгч нь банкинд татвар хураамжийг төлсөн баримтыг авч ирэхэд CAIS програмын "**Гаалийн бүрдүүлэлт**" цэсний "**Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас**" хэсгийн "**Зөвшөөрөл**" гэсэн хэсэг рүү орж тухайн Маягт№2-ыг сонгож "**Зөвшөөрөх**" товчийг дарна.

2.1. CAIS програмын "**Гаалийн бүрдүүлэлт**" цэсний "**Зорчигчийн барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас**" хэсгийн "**Зөвшөөрөл**" гэсэн хэсэг рүү орж тухайн Маягт№2-ыг сонгож "**Хэвлэх**" товчийг дарж маягтыг хэвлэнэ.

2.2.Хэвлэсэн "Маягт№2" болон холбогдох бусад хяналтын тэмдэглэгээг /НХ/ хийж, хяналт шалгалт хариуцсан Гаалийн улсын байцаагч гарын үсэг зурж, хувийн тэмдэгээр баталгаажуулалт хийнэ.

3. Маягт№2-ын **1-р хувийг** мөнгө тушаасан баримтын дугаарыг бичиж маягтанд хавсаргаж тухайн гаалийн байгууллагын нягтлан бодогчид хүлээлгэн өгнө. 2-р хувийг бараа эзэмшигчид өгнө.